



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/031/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p><b>Санхүү-нийцлийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг</b> Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:Naranchimegts@audit.gov.mn">Naranchimegts@audit.gov.mn</a> <b>Аудитын менежер: Б.Долгорсүрэн</b> Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:dolgorsurenb@audit.gov.mn">dolgorsurenb@audit.gov.mn</a> <b>Ахлах аудитор: П.Амарсанаа</b> Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:amarsanaap@audit.gov.mn">amarsanaap@audit.gov.mn</a> <b>Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн</b> Утас: 976-99115395 Цахим хаяг: <a href="mailto:info@niislelaudit.mn">info@niislelaudit.mn</a> <b>Аудитор: Л.Сарантуяа</b> Утас: 976-99118839 Цахим хаяг: <a href="mailto:l.sarantuya@niislelaudit.mn">l.sarantuya@niislelaudit.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН  
СТАНЦ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ М. БАТТУЛГА ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 07/1179  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системд үр ашигтай тохируулга хийж, оргил ачааллыг давж гарах чадвартай эх үүсвэрийг бий болгох зорилготой эрчим хүчний нэн чухал төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий аж ахуйн нэгж бөгөөд ОХУ-ын талаас өмнөх жилүүдэд тус төслийг дэмжихгүй гэсэн байр суурьтай байсан бол Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путины 2024 онд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд "Байгаль нуур болон Сэлэнгэ мөрнийг хамгаалах салбарт хамтран ажиллах" тухай санамж бичигт хоёр улсын Байгаль орчны сайд нар гарын үсэг зурсан нь төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чухал түлхэц нөлөөлөл болсон. Мөн түүнчлэн ЭГУЦС төслийн 2024 оны ажлын үр дүнд Монгол улсын хувьд ихээхэн хөрөнгө зардал цаг хугацаа зарцуулах байсан ЮНЕСКО-оос Орос Монгол хоёр улсын газар нутгийг хамарсан Бүс нутгийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг зогсоох шийдвэрийг ЮНЕСКО-гоор гаргуулсан нь төсийн хөрөнгө зарцуулалтыг хэмнэсэн чухал үйл явдал болсон байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудит нь Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахад чиглэгдсэн. Эгийн голын усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын өмнөх үйл ажиллагаа болох 2014 оноос хойш хийгдсэн судалгаа шинжилгээний ажилд зарцуулсан 16,475.4 мянган төгрөгийн зардлыг биет хөрөнгөөр буюу Дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэсэн байна.

## Бусад асуудал

Тус компани нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	93,426,627.46	95,868,329.23
1.1.2	Дансны авлага	0.00	0.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.6	Бараа материал	11,023,272.97	23,107,035.02
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	6,618,731.82	5,280,323.37
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>111,068,632.25</b>	<b>124,255,687.62</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	16,438,335,118.70	82,068,680.40
1.2.2	Биет бус хөрөнгө	18,641,637,652.51	35,119,613,112.11
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.9	...	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>35,079,972,771.21</b>	<b>35,201,681,792.51</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>35,191,041,403.46</b>	<b>35,325,937,480.13</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.1.1	Дансны өглөг	92,718,000.00	92,718,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	237,065.12	0.00
2.1.1.3	Татварын өр	6,116,138.04	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,231,989.00	1,231,989.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>100,303,192.16</b>	<b>93,949,989.00</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	59,986,142,785.14	60,616,754,341.97
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>59,986,142,785.14</b>	<b>60,616,754,341.97</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>60,086,445,977.30</b>	<b>60,710,704,330.97</b>
2.3	<b>Эздийн өмч</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.3.1	Төрийн өмч	20,000.00	20,000.00
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,635,520,000.00	18,635,520,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(43,530,944,573.84)	(44,020,306,850.84)
2.3.10	...	0.00	0.00
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>-24,895,404,573.84</b>	<b>25,384,766,850.84</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>35,191,041,403.46</b>	<b>35,325,937,480.13</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	-	-
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	-	-
4	Түрээсийн орлого	3,250,440.00	3,250,440.00
5	Хүүгийн орлого	1,351,791.80	1,443,084.99
6	Ногдол ашгийн орлого	-	-
8	Бусад орлого	949,944,392.00	760,247,215.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	530,003,095.71	632,973,925.50
11	Санхүүгийн зардал	4,293,511,883.43	1,242,151,445.58
12	Бусад зардал	4,870,600.00	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	635,080,251.44	611,122,354.09
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	(167,737,967.48)	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(3,406,496,671.38)</b>	<b>(499,062,277.00)</b>
19	Орлогын татварын зардал	-	-
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(3,406,496,671.38)</b>	<b>(499,062,277.00)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(3,406,496,671.38)</b>	<b>(499,062,277.00)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(3,406,496,671.38)</b>	<b>(499,062,277.00)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(38,686,552,803.77)	(20,051,012,803.77)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(1,437,895,098.69)	(1,437,895,098.69)
3	Залруулсан үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(40,124,447,902.46)	(21,488,907,902.46)
4	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	(3,406,496,671.38)	(3,406,496,671.38)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(43,530,944,573.84)	(24,895,404,573.84)
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	9,700,000.00	9,700,000.00
8	Залруулсан үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(43,521,244,573.84)	(24,885,704,573.84)
9	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	(499,062,277.00)	(499,062,277.00)
10	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
11	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(44,020,306,850.84)	(25,384,766,850.84)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	954,546,623.80	847,321,576.33
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	949,944,392.00	837,938,830.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,602,231.80	9,382,746.33
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,873,244,481.12	772,316,814.02
1.2.1	Ажиллагчдад төлсөн	29,756,451.97	307,328,079.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	66,285,995.78	95,030,551.76
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	102,871,631.84	167,398,657.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	48,428,917.55	4,200,000.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	29,658,645.95	-
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	22,900,298.23	45,322,047.61
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,373,342,539.80	153,037,478.43
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(918,697,857.32)</b>	<b>75,004,762.31</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,351,791.80	1,443,084.99
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,351,791.80	1,443,084.99
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	32,580,039.99	73,588,605.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	31,700,039.99	73,588,605.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	880,000.00	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(31,228,248.19)</b>	<b>(72,145,520.01)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
4	Валютын ханшийн зөрүү	-	(417,540.53)
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(949,926,105.51)</b>	<b>2,441,701.77</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,043,352,732.97</b>	<b>93,426,627.46</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>93,426,627.46</b>	<b>95,868,329.23</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
		х/н	1	2	3	4
2	<b>Нийт орлого</b>	<b>сая төг</b>	<b>1,589.60</b>	<b>1,003.30</b>	<b>1,376.00</b>	
	Үүнээс: Хүүгийн орлого	сая төг	1.30		1.40	
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	3.30	3.30	3.30	
	Улсын төсвийн санхүүжилт	сая төг	949.90	1,000.00	760.20	
	Бусад /Гадаад валютын ханшийн зөрүүний олз/	сая төг	635.10		611.10	
3	<b>Нийт зардал</b>	<b>сая төг</b>	<b>4,828.30</b>	<b>1,003.30</b>	<b>1,875.00</b>	
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал	сая төг	490.00	1,003.30	632.90	63
	Үйл ажиллагааны бус зардал /Санхүүгийн зардал/	сая төг	4,293.50		1,242.10	
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	сая төг	44.80	21.30	41.30	194
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая төг	(41.50)	-	(499.00)	
5	<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>	<b>сая төг</b>	<b>(41.50)</b>	<b>-</b>	<b>(499.00)</b>	
6	Борлуулалтын орлого 1 төг-т ноогдох зардал					
7	<b>Нийт авлага</b>	<b>сая төг</b>				
	Үүнээс: ЭХ-ний					
	Бусад					
8	<b>Нийт өглөг</b>	<b>сая төг</b>	<b>60,282.10</b>	<b>69,527.40</b>	<b>60,710.60</b>	87
	Үүнээс: Урт хугацаат өр төлбөр	сая төг	59,986.10	69,430.70	60,616.70	87
	Богино хугацаат өр төлбөр	сая төг	296.00	96.70	93.90	97
9	Нийт ажиллагсад	тоо	7.00	9.00	9.00	100
10	<b>Нийт цалингийн сан</b>	<b>сая төг</b>	<b>265.20</b>	<b>477.60</b>	<b>417.70</b>	87
11	<b>Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт</b>	<b>сая төг</b>	<b>33.90</b>	<b>80.10</b>	<b>64.30</b>	80

**3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

3.1. Аудитаар нийт 16,475.5 сая төгрөгийн алдааг залрууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Эгийн голын усан цахилгаан станцыг барьж байгуулахаас өмнөх шинжилгээ судалгааны ажлын ертгийг үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга дансанд хуримтлуулж бүртгэсэн байна.	1	16,475,455.7			1	16,475,455.7	1	16,475,455.7				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>16,475,455.7</b>			<b>1</b>	<b>16,475,455.7</b>	<b>1</b>	<b>16,475,455.7</b>				

3.2. Аудитаар нийт 4,054.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2.4 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Захирлын 2023 оны 4 дүгээр сарын 21-ны өдрийн А/12 дугаар тушаалаар баталсан "Автомашин ашиглах журам"-д шатахуун зарцуулалтын нормыг тус байгууллагын автомашинуудыг 10 жилээс дээш хугацаагаар ашиглаж байгаа гэсэн тайлбартайгаар тодорхой судалгаа үндэслэлгүйгээр зөвшөөрсөн нормоос илүү тогтоож мөрдүүлсэн.	1	1,684.6			1	1,684.6						
Тайлант онд худалдан авсан 1,069.9 мянган төгрөгийн компьютерийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.	1	1,069.9					1	1,069.9				
Иргэнтэй байгуулсан АГГ/11 тоот Автомашины гэмтлийг засварлах ажлыг гүйцэтгэх 4,450.0 мянган төгрөгийн гэрээний нийт дүнгээр татварын тооцоог хийгээгүй	1	13,00.0					1	13,00.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,054.5</b>			<b>1</b>	<b>1,684.5</b>	<b>2</b>	<b>2,369.9</b>				

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 809.6 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 688,427.8 мянган төгрөгийн 3, зарлагын 121,151.5 мянган төгрөгийн 11 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	809,579.3	1	809,579.3		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>809,579.3</b>	<b>1</b>	<b>809,579.3</b>		